



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2015 оны 01 сарын 14 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

“Мөнх даатгал” ХХК-д хувь нийлүүлсэн
хөрөнгийн хэмжээндээ өөрчлөлт оруулахыг
зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны “Даатгалын компанийн дүрмийн сангийн доод хэмжээг тогтоох тухай” 355 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:


1. “Мөнх даатгал” ХХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг тус компанийн 2014 оны хуримтлагдсан ашгаас хувьцаа эзэмшигчдэд хуваарилсан ногдол ашгийн 60,000,000 /жаран сая/ төгрөг, компанийн хувь нийлүүлэгч Т.Оюунгэрэлээс шилжүүлсэн 690,000,000 /зургаан зуун ерэн сая/ төгрөг, нийт 750,000,000.0 /долоон зуун тавин сая/ төгрөгөөр нэмэгдүүлж дараах байдлаар тогтоохыг зөвшөөрсүгэй:

| № | Хувь нийлүүлэгч | Хөрөнгийн хэмжээ /төгрөгөөр/ | | | Дүрмийн санд эзлэх хувь |
|---|-----------------|------------------------------|---------------|--------------------|----------------------------|
| | | Эхний үлдэгдэл | Өөрчлөлт | Эцсийн үлдэгдэл | |
| 1 | Ч.Отгонжаргал | 589,240,000.0 | 12,920,000.0 | 602,160,000.0 | 17.20% |
| 2 | Р.Нямсүрэн | 310,390,000.0 | 6,730,000.0 | 317,120,000.0 | 9.06% |
| 3 | Ч.Жигжид | 310,370,000.0 | 6,750,000.0 | 317,120,000.0 | 9.06% |
| 4 | Т.Оюунгэрэл | 990,000,000.0 | 711,600,000.0 | 1,701,600,000.0 | 48.61% |
| 5 | Д.Батжавхлан | 550,000,000.0 | 12,000,000.0 | 562,000,000.0 | 16.05% |
| | Дүн | 2,750,000,000.0 | 750,000,000.0 | 3,500,000,000.0 | 100,00% |

2. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд оруулсан өөрчлөлтийг тусгай зөвшөөрлийн болон улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлж, компанийн шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлэн, холбогдох баримтыг 2015 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Хороонд ирүүлэхийг “Мөнх даатгал” ХХК /Т.Оюунгэрэл /-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Ц.Энхбаяр/-нд даалгасугай.

ДАРГА



З.НАРАНТУЯА

000507